



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар A/173

Ховд

Залуучуудын хөгжлийн
салбар зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн дүрмийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Сумдад залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг шинэчлэн байгуулж, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Залуучуудын хөгжлийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, үйл ажиллагаагаа эрчимжүүлэн ажиллахыг сумдын Засаг дарга наарт үүрэг болгосугай.

3. Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, улирал бүр тайланг салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга (О.Сарангоо)-д даалгасугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл байгуулах тухай аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн A/157 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Э.БОЛОРМАА



8400001 0711
Zah A/173 Kh



Засаг даргын 2024 оны
03 дугаар сарын 21-ний өдрийн
A/173 дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Тэргүүн: - Аймгийн Засаг дарга

Дэд тэргүүн: - Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, хүүхэд, гэр бүл, хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн

- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

- Эрүүл мэндийн газрын дарга

- Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга

- Цагдаагийн газрын дарга

- Жаргалант сумын Засаг дарга

- Соёл урлагийн газрын дарга

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн дарга

- Монгол Улсын Их Сургуулийн Ховд дахь салбар сургуулийн захирал

- “Хөгжил” политехник коллежийн захирал

- Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга


- Аймгийн Залуучуудын хөгжлийн зөвлөлийн тэргүүн

- Аймгийн Залуучуудын холбооны тэргүүн

- Залуу багш нарын холбооны тэргүүн

Нарийн бичгийн дарга: - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн

-оОо-



Засаг даргын 2024 оны
03 дугаар сарын 21-ний өдрийн
А/173 дугаар захирамжийн
хоёрдугаар хавсралт

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл (цаашид "салбар зөвлөл" гэх) нь залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын уйл ажиллагааг тухайн орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвшилцлийн байгууллага мөн.

1.2. Салбар зөвлөлийн уйл ажиллагааг энэхүү дүрмээр зохицуулна.

1.3. Салбар зөвлөл нь Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, тэдгээртэй холбоотой бусад хууль тогтоомж болон энэ дүрмийг дагаж мөрдөнө.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Салбар зөвлөлийн дэд тэргүүн нь Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга байна.

2.2. Аймаг, дүүрэгт салбар зөвлөлийн ажлын албаны үүргийг тухайн орон нутгийн Залуучуудын хөгжлийн төв, нийслэлд Залуучуудын хөгжлийн газар, суманд Залуучуудын асуудал эрхэлсэн мэргэжилтэн хариуцна.

2.3. Салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга нь тухайн орон нутгийн залуучуудын асуудал эрхэлсэн нэгжийн дарга, суманд мэргэжилтэн байна.

2.4. Салбар зөвлөл нь төрийн байгууллага болон залуучуудын иргэний нийгмийн байгууллага, залуучуудын төлөөллөөс бурдсан 15-17 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.5. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг салбар зөвлөлийн тэргүүн батална.

Гурав. Салбар зөвлөлийн эрх үүрэг

3.1. Салбар зөвлөл залуучуудын хөгжлийг дэмжих тухай хулийн 22.4-т зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1. Залуучуудын эрх, хөгжил, оролцоог хангахтай холбоотой хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн талаарх тайланг хэлэлцэж зөвлөмж гаргана.

3.1.2. Залуучуудын хөгжлийн үндэсний болон орон нутгийн хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг хэлэлцэн зөвлөмж гаргах, асуудал хариуцсан байгууллагуудад чиглэл өгнө.

3.1.4. Залуучуудын хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөрөнгө оруулалт хийсэн, идэвх санаачилга гарган нийгэмд манлайлал үзүүлсэн хулийн этгээд иргэдийг алдаршуулна.

Дөрөв. Салбар зөвлөлийн гишүүний эрх, үүрэг

4.1. Салбар зөвлөлийн гишүүн дараах эрх, үүрэгтэй.

4.1.1. Залуучуудын хөгжил, хамгааллын асуудлаар санал, санаачилга гаргаж салбарын хөгжлийн төлөвлөгөөнд тусгуулах, хэрэгжилтийг дэмжих хяналт үнэлгээ хийнэ.

4.1.2 Тухайн салбарын бодлого, хөтөлбөрт залуучуудын хөгжил, хамгаалал аж байдлыг сайжруулахад чиглэсэн төсөл арга хэмжээ тусгуулж хэрэгжилтэд оролцно.

4.1.3 Салбар зөвлөлийн хуралдаанд тогтмол оролцож хэлэлцэх асуудлаар санал гаргана.

Тав. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр

5.1. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

5.2. Салбар зөвлөлийн хуралдааны төв болон хэлэлцэх асуудлыг зөвлөлийн тэргүүн батална.

5.3. Хурлыг зөвлөлийн тэргүүн, түүний эзгүйд дэд тэргүүн даргална.

5.4. Салбар зөвлөлийн тэргүүн, эсхүл салбар зөвлөлийн нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь тодорхой асуудлаар хуралдах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тэргүүний шийдвэрээр ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулна.

5.5. Ажлын алба салбар зөвлөлийн хуралдаантай холбоотой бэлтгэл ажлыг хангаж, хуралдаан болохоос ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд хурлын товыг мэдэгдэж, хэлэлцэх асуудлын жагсаалт, холбогдох баримт бичгийг хүргүүлсэн байна.

5.6. Салбар зөвлөл Үндэсний зөвлөлөөс гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

5.7. Нийт гишүүдийн 50-с дээш хувь оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

5.8. Хуралдааны ирц бүрдээгүй тохиолдолд хуралдааны ажлын 10 хоногийн дотор дахин зарлан хуралдуулна.

5.9. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд биеэр оролцох боломжгүй гишүүд хурал эхлэхээс өмнө саналаа бичгээр хүргүүлж болно.

5.10. Хуралдаанд холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулж болно.

5.11. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг олонхын саналаар шийдвэрлэж зөвлөмж гаргана.

Зургаа. Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүрэг

6.1. Зөвлөлийн Нарийн бичгийн дарга төрийн Албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж ажиллана.

6.2. Салбар зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохицуулж, хуралдааны бэлтгэлийг ханган, гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж,

тайланг нэгтгэн, салбар зөвлөлийн тэргүүн, дэд тэргүүн, гишүүдийг мэдээллээр хангана.

6.3. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, хагас жил болон жилийн эцсийн тайланг салбар зөвлөлөөр хэлэлцүүлнэ.

6.4. Зөвлөлийн Нарийн бичгийн дарга төрийн болон иргэний нийгмийн байгууллагын Залуучуудын зөвлөл, холбоо, ТББ-ын хамтын ажиллагааг хариуцан ажиллана.

-оОо-